



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/295

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулах “Чадварлаг туслах багш-2019” тэмцээнд 400.000 төгрөг зарцуулсугай.

2. Уг тэмцээнд шаардагдах 400.000 төгрөг /Дөрвөн зуун мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.11-д заасан “Хүүхэд бүр цэцэрлэг” хөтөлбөрөөс тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
5 дугаар сарын 13 –ны өдрийн
А/295 дугаар захирамжийн хавсралт



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ "ЧАДВАРЛАГ ТУСЛАХ БАГШ-2019"
ТЭМЦЭЭНД "ХҮҮХЭД БҮР ЦЭЦЭРЛЭГТ" ХӨТӨЛБӨРӨӨС
САНХҮҮЖИГДЭХ ТӨСӨВ

№	Төрөл	Байр	Шагналын сан	Дүн
1	Нэгтгэл	1 дүгээр байр	Өргөмжлөл 100.000 Мөнгөн шагнал 300000	400,000.00